

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2019.12.28

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2019 онд хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт болон тус байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлыг хамруулж үр дүнг үнэлэв.

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2019 онд 6 эрх зүйн актын 69 зүйл заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2019 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн нь **100** хувь буюу **5.0** оноотой байна.


Биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Зүйл, заалт	Зүйл заалтын гүйцэтгэлийн хувь				Дундаж	
			/0/	40	70	100	Хувь	Оноо
1	Монгол Улсын хууль	11	-	-		11	100	5.0
2	Монгол Улсын Их Хурлын тогтоол	5	-	-		5	100	
3	Ерөнхийлөгчийн зарлиг	2	-	-		2	100	
4	Засгийн газрын тогтоол	17	-	-		17	100	
5	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	29	-	-		27	100	
6	Засгийн газрын албан даалгавар	5				5		
		69	-	-		69	100	5.0

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.76 хувиар өссөн байна.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2018 он	2019 он
98.24 хувь	100 хувь



/Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 6 дугаар хавсралтаас үзнэ үү/

1.2 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тус байгууллагаас 2019 онд хэрэгжүүлэх 8 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ туссан бөгөөд эдгээр арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Хяналтад авсан 2019 онд хэрэгжүүлэх 12 арга хэмжээний биелэлтэд өгсөн үнэлгээг дараах хүснэгтэд харуулав:


№	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж	
			0	40	70	100	Хувь	Оноо
1	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д туссан 8 зорилт	12	-	-	1	11	97.5	4.87

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд **97.5** хувийн биелэлттэй байна.

/Хөтөлбөрийн биелэлтийг 7 дугаар хавсралтаас үзнэ үү/

Өмнөх онуудын үнэлгээтэй харьцуулбал:

2018 он	2019 он	Өсөлт, бууралт /+, -/
98.33 хувь	97.5 хувь	-0.83



Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ 2018 оноос 0.83 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт


Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 4 шалгуур үзүүлэлттэй, 3 арга хэмжээ туссан бөгөөд биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж **100** хувь буюу **5.0** оноотой дүгнэгдсэн.

Биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж	
			/-/	0	40	70	100	хувь	оноо
1	3	4	-	-	-	-	3	100	5.0

Өмнөх оны үзүүлэлтэй харьцуулан харвал:

2018 он	2019 он	Өсөлт, бууралт /+, -/
100 хувь	100 хувь	



/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 2 дугаар хавсралтаас үзнэ үү./

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт


Хууль зүй, дотоод хэргийн Сайдтай Ерөнхий газрын даргын байгуулсан 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 126 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 95.16 хувийн биелэлттэй байна.

2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж	
	/-/	40	70	100	Хувь	Оноо
126	1	-	20	104	95.16	4.7

Нийт 126 арга хэмжээний “үр дүнтэй” 100 хувиар дүгнэгдсэн 104, “тодорхой үр дүнд хүрсэн” 70 хувиар дүгнэсэн 20 арга хэмжээ, шалгуураас хассан 1 арга хэмжээ байна. Тодорхой үр дүнд хүрсэн 20 арга хэмжээг 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өмнөх оны төлөвлөгөөний биелэлттэй харьцуулбал:



2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд өгсөн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад 3.16 хувиар өссөн байна.

/Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 1 дүгээр хавсралтаас үзнэ үү/

2.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт


Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг **95** хувь буюу **4.7** оноогоор дүгнэв.

Биелэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж	
			/-/	0	40	70	100	хувь	оноо
1	2	5	-	-	-	1	4	95	4.7

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ, үнэлгээний тайлбар:

2018 он	2019 он	Өсөлт, бууралт /+, -/
92.5 хувь	95 хувь	+2.5
4.6 оноо	4.7	+0.1



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

Тус газрын албан хаагчдын жендэрийн харьцаа 2019 онд эрэгтэй 318 буюу 26.5 хувь, эмэгтэй 883 буюу 73.5 хувь болж жендерийн харьцааг 2018 онтой харьцуулахад 1.7 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Тайлант он	Нийт	эрэгтэй	эмэгтэй	Шалгуур үзүүлэлт			
				Зохимжтой харьцаа		Хүйсийн харьцаа	
2018	1198	338	860	40	60	28.2	71.7
2019	1201	318	883	40	60	26.5	73.5

/Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг 5 дугаар хавсралтаас үзнэ үү/

2.3 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, статистик мэдээ

Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2018 оны хэрэгжилтийг 98.3 хувь буюу 4.91 гэж үнэлсэн. Гүйцэтгэлийг доорх байдлаар танилцуулж байна.

№	Үзүүлэлт	Дундаж	
		Хувь	Оноо
1	Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа	96.93	4.84
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа	90.9	4.54
3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа	95.54	4.77
4	Улсын бүртгэлийн нэгдсэн архивын үйл ажиллагаа	98.2	4.91
5	Бүртгэлийн хяналтын шалгалтын үйл ажиллагаа	100	5
Дүн		96.3	4.81

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2019 онд нийт 773427 бүртгэл хөтөлж, хяналт шалгалтаар 4032 зөрчил дутагдал илэрч **96.93** хувь буюу **4.84** оноогоор үнэлэгдэж байна.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал:

Тайлант он	Нийт бүртгэлийн тоо	Шалгасан бүртгэлийн тоо	Зөрчилтэй бүртгэл, хувь	Зөрчилгүй бүртгэлийн эзлэх хувь
2018 он	878130	198199	3015/1.52	98.47
2019 он	773427	131188	4032/3.07	96.93

Өмнөх оноос иргэний улсын бүртгэлийн тоо 104703-аар буурч, бүртгэлийн зөрчил 1.55 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. Иргэний улсын бүртгэлийн тоо буурсан нь шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зөвхөн шилжин очсон газраа бүртгүүлдэг болсон, харин зөрчлийн тоо өссөн үзүүлэлт Улсын бүртгэлийн байгууллага 2019 онд улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан, зөрчлийг илрүүлэх, бүртгэх механизм сайжирсантай холбоотой байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2019 онд нийт 53608 бүртгэл хөтөлж, хяналт шалгалтаар 4883 бүртгэлийг шалгаснаас 759 зөрчил илэрч **90.9** хувь буюу **4.54** оноогоор үнэлэгдэж байна.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал:

Тайлант он	Нийт бүртгэлийн тоо	Шалгасан бүртгэлийн тоо	Зөрчилтэй бүртгэл, хувь	Зөрчилгүй бүртгэлийн эзлэх хувь
2018 он	52710	10291	328/3.1	96.9
2019 он	53608	4883	759/9.1	90.9

2019 онд бүртгэсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт тоо нь өмнөх онтой харьцуулахад 898-аар буюу 1.7 хувиар өсч, бүртгэлийн зөрчил 6 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. Энэ нь Улсын бүртгэлийн байгууллага 2019 онд улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан, зөрчлийг илрүүлэх, бүртгэх механизм сайжирсантай холбоотой байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр 2019 онд нийт 449936 бүртгэл хөтөлж, хяналт шалгалтаар 47233 бүртгэлийг шалгаснаас 2107 зөрчил дутагдал илэрч **95.54** хувь буюу **4.77** оноогоор үнэлэгдэж байна.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал:

Тайлант он	Нийт бүртгэлийн тоо	Шалгасан бүртгэлийн тоо	Зөрчилтэй бүртгэл, хувь	Зөрчилгүй бүртгэлийн эзлэх хувь
2018 он	433203	75150	1276/1.69	98.3
2019 он	449936	47233	2107/4.46	95.54

2019 онд бүртгэсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоог 2018 оны мөн үеийнхтэй харьцуулахад 16733 тоогоор буюу 3.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн бүртгэлийн зөрчил 2.7 хувиар өссөн байгаа нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тавих хяналт шалгалт нэмэгдсэн, Улсын бүртгэлийн байгууллага 2019 онд улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан, зөрчлийг илрүүлэх, бүртгэх механизм сайжирсантай холбоотой байна.

Улсын бүртгэлийн нэгдсэн архивын чиглэлээр:

Улсын бүртгэлийн нэгдсэн архивт 2019 оны байдлаар 23 539 481 архивын баримт хадгалагдаж байна.

Бүртгэлийн чиглэлээр нь авч үзвэл:

- ✓ Иргэний баримтын архивт 22 246 832
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт 204 844
- ✓ Эд хөрөнгийн бүртгэлийн архивт 1 087 805

Улсын бүртгэлийн архивын чиглэлээр улсын хэмжээнд 2019 онд олгосон лавлагаа, хуулбарыг хүснэгтээр харуулбал:

Тайлант он	Нийт бүртгэлийн тоо	Шалгасан бүртгэлийн тоо	Зөрчилтэй бүртгэл, хувь	Зөрчилгүй бүртгэлийн эзлэх хувь
2018 он	551703	22246	475/2.14	97.86
2019 он	488745	20653	386/1.8	98.2

2019 онд олгосон лавлагааны тоог өмнөх онтой харьцуулахад 62958 тоогоор буюу 12.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн улсын бүртгэлийн архивын чиглэлээр зөрчилтэй бүртгэлийн тоо 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа архивын баримтыг цахимжуулсан нь зөрчлийг бууруулахад нөлөөлсөн.

Бүртгэлийн хяналт шалгалтын чиглэлээр:

Бүртгэлийн хяналт шалгалтын 2019 оны жилийн эцсийн статистик мэдээний зарим үзүүлэлтийг 2018 оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулбал:

Үзүүлэлт		2018 он	2019 он	Өсөлт +/, Бууралт /-	
				Тоо	Хувь
Хяналт, шалгалтын нэгдсэн тоо		4318	6160	1842	42.65
үүнээс	Графикийн дагуу	367	425	58	15.80
	Өргөдөл, санал гомдлын мөрөөр	3951	5735	1784	45.15
Зөрчлийн шийдвэрлэлт	Илрүүлсэн зөрчил	38614	37858	-710.84	-1.84
	Эрх бүхий хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	26	40	14	53.84
	Зөрчлийн хуулиар хялбаршуулсан журмаар торгосон иргэн, хуулийн этгээдийн тоо	38588	37818	-770	-1.99
	оногдуулсан торгуулийн хэмжээ /мян.төг/	1077167	1115374	38207	3.54

2019 оны жилийн эцсийн хяналт шалгалтын нэгдсэн тоог 2018 оны мөн үетэй харьцуулахад 1842 буюу 42.65 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэдээс ирүүлж байгаа улсын бүртгэлтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо 2018 оны мөн үеийнхтэй харьцуулахад 45.15 хувиар өссөн байгаа нь Зөрчлийн тухай хуулиар хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж байгаа өргөдөл, гомдол улсын хэмжээнд нэмэгдсэнтэй шууд хамааралтай байна.

Улсын бүртгэлтэй холбоотой шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 2019 оны жилийн эцсийн тоог 2018 оны мөн үеийнхтэй харьцуулахад 53.84 хувиар өссөн байгаа нь Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган

ажиллаж, Зөрчлийн харьяаллын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлж байгаатай холбоотой байна.

Улсын байцаагч нарын 2019 онд оногдуулсан торгуулийн хэмжээг 2018 мөн үеийнхтэй харьцуулахад 3.54 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэний улсын бүртгэлийн 2019 оны статистик мэдээнд хийсэн дүн шинжилгээ

Иргэний улсын бүртгэлийн 2019 оны жилийн эцсийн статистик мэдээг 2018 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулж дүн шинжилгээ хийхэд:


Д/д	Статистик мэдээллийн үзүүлэлт	2018 он	2019 он	Өсөлт/+,Бууралт/-/	
				тоо	хувь
1	Монгол Улсын нийт иргэн	3240385	3302283	61898	1.9
	Эрэгтэй	1604963	1635621	30658	1.9
	Эмэгтэй	1635422	1666662	31240	1.9
2	Төрсний бүртгэл	77416	80129	2713	3.5
	Эрэгтэй	39553	41085	1532	3.8
	Эмэгтэй	37863	39044	1181	3.1
3	Гэрлэсний бүртгэл	20435	19992	-443	-2.1
	Анхны	17551	17201	-350	-1.9
	Дахин	2835	2739	-96	-3.3
	Сэргээсэн	49	52	3	6.1
4	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	4078	4247	169	4.1
	Захиргааны журмаар	1241	1384	143	11.5
	Шүүхийн журмаар	2837	2863	26	0.9
5	Үрчлэлтийн бүртгэл	1495	1671	176	11.77
	Монгол Улсын иргэнд	1480	1663	183	12.36
	Гадаад Улсын иргэнд	15	8	-7	-46.66
6	Нас баралтын бүртгэл	17429	18281	852	4.9
	Эрэгтэй	10615	11292	677	6.3
	Эмэгтэй	6814	6989	175	2.6

7	Гадаадын иргэдийн гэр бүлийн байдлын бүртгэл	551	494	-57	-10.3
	Гэрлэсний бүртгэл	237	198	-39	-16.4
	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	62	66	4	6.4
	Холимог гэр бүлд төрсөн хүүхдийн бүртгэл	175	190	15	8.5
	Эцэг тогтоолтын бүртгэл	64	32	-32	-50
	Үрчлэлтийн бүртгэл	13	8	-5	-38.4
8	Иргэний цахим үнэмлэх	224864	212634	-12230	-5.4
	Шинээр олгосон иргэний цахим үнэмлэх	50582	43981	-6601	-13
	Хугацаа сунгасан /25 нас/	51737	46043	-5694	-11
	Хугацаа сунгасан /45 нас/	44676	41215	-3461	-7.7
	Дахин олгосон иргэний цахим үнэмлэх	77869	81395	3526	4.5
9	Үндэсний гадаад паспорт	377178	343652	-33526	-8.8
10	Шилжилт хөдөлгөөний бүртгэл	30534	31226	692	2.2

Монгол Улсын нийт иргэн

Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 3302283 хүн ам бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеийн хүн амын тооноос 1.9 хувиар өссөн байна.


Зураг 1.1: Нийт хүн амын бүртгэл /жилээр, тоогоор/



Төрөлт болон нас баралт

2019 онд нийт 80129 төрөлт, нас баралтын бүртгэл 18281 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 2713 буюу 3.50 хувиар, нас баралт 18281 буюу 4.90 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1.2: Төрөлт, нас баралтын бүртгэл /жилээр, тоогоор/




Гэрлэсний болон гэрлэлт дуусгавар болсны бүртгэл

Тайлант оны жилийн эцсийн байдлаар гэрлэсний бүртгэл 19992 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеэс -443 буюу -2.16 хувиар буурсан байна.

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 4247 бүртгэгдсэн нь 2018 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 169 буюу 4.14 хувиар өссөн, үүнээс шүүхийн журмаар бүртгүүсэн бүртгэл дийлэнх хувийг эзэлж байна.


Зураг 1.3: Гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /жилээр, тоогоор/



Гадаадын иргэдийн бүртгэл

Гадаад иргэдтэй гэрлэсний бүртгэл 2019 онд 198, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 66 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэрлэсний бүртгэл -39 хувиар буурсан, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 4 буюу 6.45 хувиар өссөн байна.

Зураг 1.4: Гадаад иргэдийн бүртгэл /жилээр, тоогоор/




Иргэний цахим үнэмлэхийн бүртгэл

Иргэний цахим үнэмлэх 2019 онд нийт 212634, шинээр 43981, хугацаа сунгасан /25,45/ 87258, дахин авсан 81395 иргэн авсан.

Эдгээрийг өмнөх оны мөн үеийн харьцуулахад дахин олголт 4.52 хувиар өссөн, хугацаа сунгалт -9.49 хувиар буурч, шинээр авсан иргэний үнэмлэх -13.05 хувиар нийт бүртгэл -12230 буюу -5.43 хувиар тус тус буурсан байна.

Зураг 1.5: Иргэний цахим үнэмлэх олголт / жилээр, тоогоор /



Үндэсний гадаад паспортын бүртгэл

Үндэсний гадаад паспортыг 2019 онд 343652 иргэн авсан нь өмнөх оноос -33526 буюу -8.88 хувиар буурсан байна.

Иргэний шилжилт хөдөлгөөн

Аймаг, хот руу шилжин ирсэн бүртгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 31226 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 692 буюу 2.26 өссөн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2019 оны статистик мэдээнд хийсэн дүн шинжилгээ


Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2019 оны жилийн эцсийн статистик мэдээ 2018 оны мөн үеийнхтэй харьцуулж хийсэн дүн шинжилгээг хүснэгтээр харуулбал:

Д/д	Статистик мэдээллийн үзүүлэлт	2018 он	2019 он	Өсөлт /+/, бууралт /-/	
				Тоо	Хувь

1	Хувьцаат компани	8	7	-1	-12.5
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11712	12190	478	4.08
3	Нөхөрлөл	760	399	-361	-47.5
4	Хоршоо	67	53	-14	-20.8
5	Төрийн бус байгууллага	2476	2323	-153	-6.17
6	Сан	133	165	32	24
7	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	91	130	39	42.85
8	Шашны байгууллага	21	29	8	38.09
9	Хадгаламж, зээлийн хоршоо	41	30	-11	-26.82
10	Гадаадын хөрөнгө оруулалттай компани	481	216	-265	-55.09
11	Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд	752	712	-40	-5.31

2019 онд шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 478 буюу 4.08 хувиар өссөн, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн бүртгэл -265 буюу -55.09 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2.1: Хуулийн этгээдийн улсын бүртгэл /жилээр, тоогоор/



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2019 оны статистик мэдээнд хийсэн дүн шинжилгээ


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2019 оны жилийн эцсийн статистик мэдээг 2018 оны мөн үеийнхтэй харьцуулахад:

Д/д	Статистик мэдээллийн үзүүлэлт		2018 он	2019 он	Өсөлт /+/, бууралт -/	
					Тоо	Хувь
1	Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл	Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	28605	29993	1388	4.85
		Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт	388	243	-145	-37.37
2	Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл	Төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл	25	23	-2	-8.00
		Төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт	31732	21110	-10622	-33.47
		Газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	1298	49065	47767	3680.05
3	Нийт анхны бүртгэл		62048	100434	38386	61.87
4	Гэрээний эрхийн бүртгэл	Худалдах, худалдан авах гэрээ	37451	40243	2792	7.46
		Бэлэглэх гэрээ	10575	9833	-742	-7.02
		Арилжих гэрээ	960	1037	77	8.02
		Гэрээслэл, Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	4303	4636	333	7.74
		Албан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх гэрээ	37	38	1	2.70
		Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	635	579	-56	-8.82
		Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ	8701	8192	-509	-5.85
		Барьцааны гэрээ	147081	140621	-6460	-4.39

	Барьцааны дуусгавар бүртгэх	эрх болсныг	116548	108128	-8420	-7.22
	Бусад гэрээ		476	839	363	76.26
5	Гэрээний эрхийн бүртгэл нийт		326767	314146	-12621	-3.86
6	Бусад бүртгэл		44388	35356	-9032	-20.35
7	НИЙТ БҮРТГЭЛ		433203	449936	16733	3.86

2019 оны жилийн эцсийн байдлаар бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16733 буюу 3.86 хувиар өссөн, дийлэнх хувийг гэрээний эрхийн бүртгэл эзэлж байна.


Зураг 3.1: Нийт бүртгэл /жилээр, тоогоор



Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх

2019 онд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 61.87 хувиар өссөн харагдаж байгаа боловч үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл 1388 буюу 4.85 хувиар, төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн бүртгэл -145 буюу -37.37 хувиар буурсан байна.

Зураг 3.2: Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх жилээр, тоогоор/



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2019 оны жилийн эцсийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн тоо өссөн байгаа нь газрын албанаас эзэмших, ашиглах эрх олгож байгаа бүх бүртгэл дундын мэдээллийн сангаар дамжин эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдэж цахимаар дугаар олгогдож эхэлсэнтэй холбоотой .

ГУРАВ .БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ


Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 11 дүгээр хавсралтын шалгуур үзүүлэлтийн дагуу үндсэн 14 чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.

Хүснэгтээр харуулбал:

№	Шалгуур үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/
1	Үйл ажиллагааны ил тод байдал	9	91.4
2	Хүний нөөцийн ил тод байдал	5	88
Нийт дундаж		14	89.7

Байгууллагын ил тод байдлын үнэлгээний биелэлтэд 2019 онд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн нь **89.7** хувь буюу **4.5** оноотой байна. Өмнөх оны үнэлгээ харьцуулвал 4.5 хувь буюу 0.1 оноогоор өссөн байдал харагдаж байна.

2018 он	2019 он
88.85	89.7
4.4	4.5



/Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайланг 3 дугаар хавсралтаас үзнэ үү./


3.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар тутам хяналт тавьж, улирал тутам Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэдээг хүргүүлж ажиллав. Салбарын хэмжээнд нийт 23 нэгжийн 3427 мэдээлэл байршуулахаас 3326 мэдээллийг бүрэн хуулийн хугацаанд, 78 мэдээллийг хугацаа хоцроож байршуулж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 97.1 хувь буюу 4.8 оноогоор дүгнэв.

Өмнөх жилийн үзүүлэлтэй харьцуулан харвал:

Тайлант он	Жилийн дундаж хувь	Оноо

2018 он	94.5 хувь	4.7
2019 он	97.1 хувь	4.8



Улсын бүртгэлийн байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилт ханган Шилэн дансны цахим хуудсанд 2019 онд мэдээлэл байршуулсан байдлыг 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.6 хувиар өссөн үзүүлэлт гарч байна.

3.2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал

Нийт хууль хэрэгжүүлэгч 23 газар, хэлтэс Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээллийг олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2019 онд 23 нэгж 20 төрлийн мэдээллийг давтамжтайгаар нийт 3427 мэдээллийг мэдээлсэн бөгөөд Шилэн дансны хуулийн хэрэгжилт 97.1 хувьтай ($3326/3427 \cdot 100$) байна.

3.2.2. Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт

Шилэн дансны цахим хуудсанд:

- Төсөв гүйцэтгэлийн 9 төрлийн мэдээлэл;
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл;
- Бусад 6 төрлийн мэдээлэл;

Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгжийн байршуулах 20 төрлийн мэдээг давтамжтай байршуулсан тоон үзүүлэлт, мэдээний төрлөөр ангилан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Байршуулах мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцор сон	Мэдээлсэн хувь
	1.Төсөв/гүйцэтгэл					
1.	Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)	23	23	-	-	100
2.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)	368	368	360	8	97.8
3.	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)	276	276	269	7	97.5
4.	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)	46	46	46	-	100

5.	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)	46	46	46	-	100
6.	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)	276	276	270	6	97.8
7.	Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)	46	46	46	-	100
8.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)	23	23	23	-	100
9.	Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)	23	23	21	2	91.3
	Төсөв, гүйцэтгэлийн дүн	1127	1127	1081	23	-
	2.Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:					
1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (бүтэн жилээр)	23	23	19	4	82.6
2.	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (бүтэн жилээр, сар бүр)	299	299	288	11	96.3
3.	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (тухай бүр)	276	276	271	5	98.2
4.	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (тухай бүр)	276	276	271	5	98.2
5.	Худалдан авах ажиллагааны тайлан (улирлаар)	23	23	23	-	100
	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын дүн	897	897	872	25	-
	3. Бусад					
1.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (тухай бүр)	276	276	270	6	97.8
2.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр,	276	276	269	7	97.5

	авлага үүсгэсэн аливаа шийдвэр (тухай бүр)					
3.	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (бүтэн жилээр)	23	23	22	1	95.7
4.	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (тухай бүр)	276	276	272	4	98.6
5.	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (сар бүр)	276	276	269	7	97.5
6.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (тухай бүр)	276	276	271	5	98.2
	Бусад нийт дүн	1403	1403	1373	30	-
	ДҮН	3427	3427	3326	78	97.1

/Шилэн дансны хөтлөлтийн биелэлтийг 4 дүгээр хавсралтаас үзнэ үү/

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны үйл ажиллагааг “**Маш сайн**” гэж үнэлж байна.

Үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо /5-с/	
1	2	3	4	5	
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100	0.6	4.8	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	97.5			
	3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	100			
	4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	96.93			
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	95.16	0.2		
	2.Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	95			
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод нээлттэй байдлын үнэлгээ	89.7	0.2		
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	97.1			
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ :		96.4	1.0		

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 онд хэрэгжүүлсэн үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн нь **96.4** хувь буюу **4.8** оноотой байна. Энэ нь 2018 оны нэгдсэн үнэлгээнээс 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй дүгнэгдсэн.

Тус байгууллагын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төлөвлөгөөт ажлын биелэлт хангалттай, ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, ил тод байдлын үнэлгээ өмнөх жилээс сайжирсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар 2019 онд дараах ололттой ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгов. Төрийн үйлчилгээний зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах, шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгох зорилгоор улсын бүртгэлийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 7 дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинэчлэн батлагдсан дүрэм, журамд иргэдээс гарах үйл ажиллагааны зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах зорилгоор шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн дараах өөрчлөлтүүд тусгагдсан.

2. Цахим үйлчилгээний систем www.burtgel.mn-г нэвтрүүлж, хэрэглээнд оруулав.

Улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээний цахим систем /www.burtgel.mn/-ийг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх мэдээллийн системд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системтэй холбосон. Өөрөөр хэлбэл улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлэх 85 төрлийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна.

3. Бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй анхан шатны нэгж болох хороо сумдыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбосон.

2019 онд улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд 152 хороо, 242 сум суурин холбогдоод байна.

4. Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамж авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэв.

Сангийн яамтай хамтран “Цахим төлбөрийн баримтын систем” /e-barimt/ аппликейшныг ашиглан улсын бүртгэлийн 105 төрлийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх боломж бий болсон. 2019 онд төрийн төлбөр тооцооны e-barimt апплейкшнээр 1442 иргэн төлбөр төлж, үйлчилгээ авсан байна. Мөн “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран үйлчилгээний хөлсийг КИОСК машинаар төлөх үйлчилгээг 2019 оны 7 дугаар сараас эхлэн бүртгэлийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлэн ажиллав. Тус машины тусламжтайгаар улсын бүртгэлийн 18 төрлийн үйлчилгээний үнэ, хураамжийг 10-20 секундийн хугацаанд шуурхай төлж, 2019 онд иргэний улсын бүртгэлийн 21 төрлийн үйлчилгээг 29543 иргэн авсан.

5. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх, улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх программ хангамж болон улсын бүртгэлийн тайлан ба удирдлагын нэгдсэн систем боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэ ажлын хүрээнд мэдээллийн сангийн 14 багц 26 программ болон тайлан удирдлагын системийг хөгжүүлж дууссан.

6. Үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлэв.

Иргэний улсын 10 төрлийн бүртгэлийг харьяалал харгалзахгүй хөтөлдөг болсон, иргэн тоон гарын үсэг, биеийн давхцахгүй өгөгдөл болон бусад хэлбэрээр өөрийгөө мөн болохыг нотолсон тохиолдолд цахим бүртгэл, цахим үйлчилгээ авах боломжтой болсон, улсын бүртгэл хөтлөх хугацааг тодорхой болгосон, үндэсний энгийн гадаад паспортын хугацааг 10 жил болгосон, хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэлийг цахим хэлбэрээр авдаг болсон, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх хугацааг багасгаж, тодорхой болгосон, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх хугацааг 3-30 хоног байсныг 3-15 хоног болгон багасгасан зэрэг болно.

2019 оны 11 дүгээр сараас Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил/-үүд болон нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

7. Бүртгэлийн үйлчилгээнд цахим нотариатын системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.

“Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам” болон Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээний төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/22 дугаартай тушаалаар батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нотариатчтай мэдээлэл солилцох дундын мэдээллийн сангийн програмыг зохиож, хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журмын хэрэгжилтийн хүрээнд Монголын нотариатчдын танхимын гишүүн 11 нотариатчтай Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг байгуулав.

8. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлэв.

2019 оны 1 дүгээр сараас эхлэн Засгийн газрын 2018 оны 186 дугаар тогтоолоор байгуулагдсан хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, шинээр болон гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдийг улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу хөтөлж байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР